

ҮҮНС:

1. Өөрийн улсын иргэдийн өрөгдлийг хулээн авах бугоу туунийг гэрчлэх.
2. Консулыг томилсон улсын иргэдийн нэг талын хуулийн гэрээ буюу гэрээслэлийг хадгалахаар хулээн авах буюу зохиож гэрчлэнэ.
3. Консул нь суугаа орондоо байгаа харьяаныхаа газар ба орон сууцыг хэрэглэх эрхийг шилжуулэх буюу албан ёсны болгох хуулийн гэрээнээс бусад өөрийн улсын иргэдийн хоорондох хуулийн гэрээг зохиож гэрчлэнэ.
4. Хэрэв гэрээ нь консулыг томилсон улсын ашиг сонирхолд онц чухал буюу өөрийн орны нутаг дэвсгэр дээр биелэгдэх бол консул нь өөрийн улс ба суугаа орны иргэдийн хооронд хуулийн гэрээг зохиож гэрчлэнэ.
5. Консул нь өөрийн улсын иргэдийн бух төрлийн баримт бичиг дээрх гарын усгийг гэрчлэх, суугаа ба тошлсон улсын байгууллага, албаны хумуусээс олгосон баримт бичгуудийг тодруулах, туунчлэн тэдгээрийн хуулбар ба хэсэглэн авсныг гэрчлэнэ.
6. Консул нь өөрийн улсын ба суугаа орны байгууллага, албаны хумуусээс олгосон баримт бичгийн орчуулгыг гэрчлэнэ.
7. Консул нь өөрийн улсын иргэдийн буюу тэдэнд зориулсан эд хөрөнгө, баримт бичгуудийг, хадгалахаар хулээн авна.
8. Консул нь өөрийн улстай холбогдол бүхий бусад ажил хэргийг гуйцэтгэнэ.

Арван тавдугаар зүйл

14-р зүйлд заасан консулын зохиож гэрчилсэн баримт бичиг, хуулбар, зэрэг нь суугаа орны зохих байгууллага, албаны хумуусийн гэрчилгээтэй бол суугаа оронд нэгэн адил хуулийн хучинтэй.